



## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 10 дугаар сарын 18

Дугаар 17

Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 17 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“8.Хотын стандартыг мөрдүүлэх бэлтгэл арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай” А/851 дугаар захирамжийн биелэлтийн талаар Хотын стандарт, хяналтын газрын дарга С. Төмөрдулам танилцуулав.

Энэ асуудалтай холбогдуулан:

1.Хотын стандартын талаарх мэдээ, мэдээллийн давтамжийг нэмэгдүүлэх, иргэд, олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг эрчимжүүлж ажиллахыг Хотын стандарт, хяналтын газар (С.Төмөрдулам), Нийслэлийн Сургалт, судалгаа олон нийттэй харилцах газар (Г.Хонгорзул)-т;

2.Хотын стандартыг мөрдүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих, аж ахуй нэгж байгууллагуудад сурталчлан таниулах, сургалт арга зүйгээр хангах зэрэг арга хэмжээг хариуцсан салбар, чиг үүргийнхээ хүрээнд 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад;

3.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ажлын үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтэд хотын стандартыг мөрдүүлэх, сурталчилан таниулах талаар хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тусгаж, хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт- шинжилгээ, үнэлгээний хэлтэс /Х. Гантулга/-т;

4.Хотын стандартыг мөрдүүлж эхэлсэнтэй холбогдуулан нэгдсэн зөвлөгөөн зохион байгуулах удирдамж, төлөвлөгөөний төсөл боловсруулж танилцуулахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (И.Баатархүү), Хотын стандарт, хяналтын газар (С.Төмөрдулам)-т тус тус үүрэг болгов” гэжээ.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



111020000168